Аудитын код: САГ-2018/15/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Аудитор Г.Мөнхчимэг
Х.Ундрага
Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
undragakh@audit.gov.mn

Улаанбаатар хот

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АГУУЛГА

Аудитын гэрчилгээ 0

1 Аудитын тайлан 3

1.1 Оршил 3

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага 3

1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин 4

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 4

1.5 Дотоод хяналт 5

1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 5

1.7 Шилэн дансны мэдээлэл 5

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар 6

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл 6

1.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан талаар 5

1.9.2 Авлагын талаар 6

1.9.3 Өр төлбөрийн талаар 5

1.9.4 Төсвийн гүйцэтгэлийн талаар 5

1.9.5 Цалингийн талаар 5

1.9.6 Дуусаагүй барилгын талаар 5

1.9.3 Зардлын талаар 6

1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал 8

1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд 9

1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 9

1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: 9

1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл 9

2 Менежментийн захидал 10

2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан 8

2.2 Өр төлбөрийн талаар .....

2.3 Төсвийн гүйцэтгэлийн талаар 11

2.4 Талингийн талаар 11

2.5 Зардлын талаар 11

3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 16

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан 16

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 19

3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 23

3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан 24

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 27

3.6 Аудитын тайлангийн хавсралт 29

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018. 03.23 № 01/803
танай _____-ны № _____-т

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭНХТҮВШИН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG26.Docx

071495

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ОЮУНБИЛЭГ

УХ-10122

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG25.Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1 АУДИТЫН ТАЙЛАН

1.1 ОРШИЛ

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 28-наас 2018 оны 3 дугаар сарын 23–ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Г.Мөнхчимэг, гэрээт аудитор Х.Ундрага нар хариуцаж хэрэгжүүлэв.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018

оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/169 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цаг уур, орчны шинжилгээний газрын эрхэм зорилго нь ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршиж байна.

Агентлаг нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Үүнд:

Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас үүсч болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;

Ус цаг уур, орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх;

Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчид шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;

Байгаль орчны улсын мэдээллийн сан, архив үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

ТАБ-СТА-А-1 Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМСОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 16 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

САГ-2018/15/СТА-ТТЗ

Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous”програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.5 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дотоод хяналт санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

1.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Цаг уур, орчны шинжилгээний газрын хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**22,066.5**	**21,876.5**	**190.0**
Урсгал зардал	22,066.5	21,876.5	190.0
Бараа үйлчилгээний зардал	20,858.0	20,819.2	38.8
Урсгал шилжүүлэг	1,208.5	1,057.3	151.2
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	**22,066.5**	**21,876.1**	**190.4**
Улсын төсвийн санхүүжилт	21,996.6	21,810.0	186.6
Үйл ажиллагааны орлого	69.9	66.1	3.8

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан төлөвлөгөөгөөр 22,066.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын гүйцэтгэл нийт 21,876.5 сая төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан.

1.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас chttps://www.shilendans.gov.mn/ сайтад шилэн дансны цэсийг холбосон байна.

ТӨСВИЙН АУДИТЫН ЗАЙЛГҮЙ ГАРГАЛТ
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна.

Тайлант онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа,зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналын талаар

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 26 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тус газрын харьяа 18 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргуулж, 2 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын хуулийн итгээд, 3 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

   Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,754.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 11.1 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт, 73.1 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 94.7 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж 1,575.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар 17 зөвлөмж өгсөн байна.

   Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "*Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "*Үнэн зөв байх*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Дээрх хуулиудыг хэрэгжүүлж, төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэх.

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа Баянхонгор аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т “...санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, дүгнэлт авсан, ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ гэж заасны дагуу Дээрх хязгаарлалтай дүгнэлт авсан байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах талаар албан шаардлага өгөх.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9.2 Авлагын талаар

Цаг уур, орчны шинжилгээний газрын аппаратын тайланд олон жил найдваргүй авлагаар бүртгэгдсэн "*Ардир*" ХХК-иас авах авлагыг шийдвэргүйгээр 7.5 сая төгрөгийг данснаас хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралтын 14 дүгээр зүйлийн 4.14-т "*Найдваргүй авлагыг бүртгэхдээ авлагыг хорогдуулах хэмжээ, баримтлах зарчим, нөхцөлийг заасан эрх бүхий байгууллагын найдваргүй болсон авлагыг данснаас хасах тухай шийдвэрийг үндэслэнэ. Шийдвэр гартал уг найдваргүй болсон авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгана*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.3 Өр төлбөрийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 7 байгууллага нийт 15.8 сая төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.4 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,066.5 сая төгрөгөөр батлагдсанаас 21,876.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийт батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч дараах зардлуудыг хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд:

- Цалингийн зардлын төсөв 65.4 сая төгрөг,
- Тэтгэврийн даатгалаас 6.8 сая төгрөг,
- ҮОМШӨ-ний даатгал 3.3 сая төгрөг,
- Гэрэл цахилгааны зардал 1.5 сая төгрөг,
- Байрны түрээсийн зардал 0.4 сая төгрөг,
- Бичиг хэргийн зардал 7.8 сая төгрөг,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс зардал 5.8 сая төгрөг,
- Урсгал засварын зардлаас 4.0 сая төгрөг,
- Банкны үйлчилгээний хураамжийн зардлаас 0.1 сая төгрөгөөр нийт 95.1 сая төгрөгийг батлагдсан төсвийн зардлын ангиллаар хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох*" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "*батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах*", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

1.9.5 Цалингийн талаар

Тайлант онд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 07-ний Б/07 тушаалаар Т.Амартайванг нь ажлаас халсан боловч нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 0.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 27.2.4 дахь "*Төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно*" гэсэн заалт болон "*Хөдөлмөрийн дотоод журмыг*" зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

1.9.6 Дуусаагүй барилгын талаар

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод аймгийн Халх гол сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилга барих гүйцэтгэгчээр “Ганганууp өргөө” ХХК шалгарч 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдөр барилгын ажлыг хүлээлгэн өгөхөөр 49.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй УТ-2012/30 дугаартай барилга угсралтын ажлын гэрээг 2012 оны 6 дугаар сарын 5-нд байгуулсан байна.

Гүйцэтгэгч компанид нийт 39.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч захиалагч байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газар 21.2 сая төгрөгөөр дуусаагүй барилга дансанд бүртгэсэн уг барилгын зөвхөн газар шороо, суурийн ажил хийгдсэн байдалтай байгаа нь Төсвийн тухай хуулийн “... 14.2.3”, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *“... журмын 4.2 захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана”,* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Тус барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах. Цаашид зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага өгөх.

1.9.7 Зардлын талаар

Тайлант онд Цаг уур, орчны шинжилгээний газар нь 12.5 сая төгрөгийн урсгал засварын хийсэн нь УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 09-ны өдрийн 47 дугаар тогтоол, БОАЖС-ын 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/125 тушаал "*Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай*" 2 дугаар зүйлийн Ё-д "*Төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх"* гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Засгийн газрын тогтоол, Салбарын сайдын тушаалыг хэрэгжүүлж ажиллах. Цаашид зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгөх.

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад иргэний мэдээллийн дагуу 10 асуудлыг шалгасан бөгөөд 1 зөрчилд зөвлөмж өгч бусад асуудал нь санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө байхгүй байна гэж үзлээ. Тайлбарыг нотлох баримтын хамтаар ажлын баримтанд хавсаргасан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,906.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. 11.1 сая төрөгийн 8 акт, 94.3 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 102.2 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 1,699.3 сая төгрөгийн материаллаг бус зөрчилд 21 зөвлөмжийг хүргүүлэв.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цаг уур, орчны шинжилгээний газрын өмнөх онд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад өгсөн 22 зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 11-ны 10/35 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "*Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх ажлын удирдамж*"-ийн дагуу хэрэгжилтийг шалгахад 100 хувийн биелэлттэй байна.

1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төсөвт байгууллагад санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,476.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 489.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хэмжээ өөрчлөгдөөгүй болно.

1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

1.16 Аудитын үр өгөөж

Цаг уур, орчны шинжилгээний газар нь тайлант онд 7.5 сая төгрөгийн найдваргүй авлагыг данс бүртгэлээс шийдвэргүйгээр хассаныг аудитын явцад залруулж санхүүгийн үр өгөөж бий болгов.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Цаг уур, орчны шинжилгээний газрыннягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дараалаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

2.1 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТ, ТАЙЛАГНАЛ	Тэргүүлэх ач холбогдол №1
ҮАГ-ын ажиглалт	**ҮАГ-ын зөвлөмж**
Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 26 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тус газрын харьяа 18 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргуулж, 2 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын хуулийн итгээд, 3 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.	Дээрх хуулиудыг хэрэгжүүлж, төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэх.
Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,754.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 11.1 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт, 73.1 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 94.7 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж 1,575.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар 17 зөвлөмж өгсөн байна.	
Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "*Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "*Үнэн зөв байх*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.
Эрсдэлүүд	**Төсвийн захирагчийн хариу**
Санхүүгийн тайлан алдаатай буруу илэрхийлэгдэх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах	Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.2 ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
ҮАГ-ын ажиглалт	**ҮАГ-ын зөвлөмж**
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 7 байгууллага нийт 15.8 сая төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.
Эрсдэлүүд	**Төсвийн захирагчийн хариу**
Санхүүгийн тайланд өр төлбөр тусгагдаагүй байх буюу зөрүүтэй илэрхийлсэн байх, өглөгийг насжилтаар нь ангилж, судалгаа хийгээгүй байх, өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байх	Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

2.3 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
ҮАГ-ын ажиглалт	**ҮАГ-ын зөвлөмж**
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,066.5 сая төгрөгөөр батлагдсанаас 21,876.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийт батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч дараах зардлуудыг хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд: - Цалингийн зардлын төсөв 65.4 сая төгрөг, - Тэтгэврийн даатгалаас 6.8 сая төгрөг, - ҮОМШӨ-ний даатгал 3.3 сая төгрөг, - Гэрэл цахилгааны зардал 1.5 сая төгрөг, - Байрны түрээсийн зардал 0.4 сая төгрөг, - Бичиг хэргийн зардал 7.8 сая төгрөг, - Бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс зардал 5.8 сая төгрөг, - Урсгал засварын зардлаас 4.0 сая төгрөг, - Банкны үйлчилгээний хураамжийн зардлаас 0.1 сая төгрөгөөр нийт 95.1 сая төгрөгийг батлагдсан төсвийн зардлын ангиллаар хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох*” 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “*батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах*”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.	Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх; Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.
Эрсдэлүүд	**Төсвийн захирагчийн хариу**
Байгууллагын дотоод хяналт ажиллахгүй байх, батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах,холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх	Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 ЦАЛИНГИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
ҮАГ-ын ажиглалт	**ҮАГ-ын зөвлөмж**
Тайлант онд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 07-ний Б/07 тушаалаар Т.Амартайванг нь ажлаас халсан боловч нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 0.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 27.2.4 дахь "*Төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно*" гэсэн заалт болон "*Хөдөлмөрийн дотоод журмыг*" зөрчсөн байна.	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх; Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.
Эрсдэлүүд	**Төсвийн захирагчийн хариу**
Батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах,холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх	Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

2.5 ЗАРДЛЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
ҮАГ-ын ажиглалт	**ҮАГ-ын зөвлөмж**
